



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/08/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Энхжаргал

Утас: 99434344

Цахим хаяг: Enkhjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2024.03.15 № 1/131  
танай 2024.03.06-ны № А/28 -Т

МАНХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Т.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын түүхт ойн арга хэмжээний хандивын орлого, зарцуулалт, мал, эд хөрөнгийн тооцоо бодоогүй, санхүүгийн тайланд тусгаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, ойд иргэд аж ахуйн нэгж байгууллагаас бэлнээр хандивласан мөнгө, хандивын хөрөнгийн зарцуулалтын анхан шатны баримтгүйгээс нотлох боломжгүй, ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй ажлуудыг баталж, санхүүжүүлсэн, зарим ажил төсөл арга хэмжээ хийгдээгүй он дамжсан, төсөв эдийн засгийн үзүүлэлт тооцоогүй, худалдан авах ажиллагааг зөрчин шууд гэрээ байгуулсан, ажил хүлээж авсан тухай акт шаардлага хангахгүй, Засаг даргын нөөц хөрөнгөөс нэг төрлийн үйл ажиллагаанд олон удаагийн захирамжаар хөрөнгө зарцуулсан, эд хариуцагчийн дансаар дамжуулан ажил гүйлгээг зарцуулсан ч хэнд хүлээлгэн өгсөн нь тодорхой бус, хувь хүмүүсээс авах авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй, шатахууны зардлын ажил гүйлгээг анхан шатны баримтгүй шилжүүлсэн, жолоочийн тооцоо бодож замын хуудас баталгаажуулаагүй зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.3.2-т "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх", гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй "Иж бүрэн байх", Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын Эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 12/02 дугаар тогтоолоор татвар, татварын бус орлогыг 468,841,7 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 535,047,3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 66,205.6 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд сум байгуулагдсаны 100 жилийн ойг зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 382,640.5 мянган төгрөг, 215 толгой мал, 8 ширхэг зөөврийн компьютерыг хандиваар хүлээн авсан байна. Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар авсан 308,690.5 мянган төгрөгийн хандивын орлогыг санхүүгийн тайланд тусгаж, ойн арга хэмжээнд бэлэн өгсөн мөнгө, мал, хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 18/03 тоот тогтоолоор "сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2023 оны хэрэгжилтийг 90.3 хувь буюу "хангалттай" гэж дүгнэжээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	403,719.4	515,234.6
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	201,069.3	197,313.6
33	<b>АВЛАГА</b>	142,429.0	232,300.2
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	34,000.0
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	40,285.0	43,620.8
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	19,936.0	8,000.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	4,378,891.3	5,511,997.0
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,378,891.3	5,511,997.0
39200	Биет хөрөнгө	4,286,176.4	5,419,469.0
39300	Биет бус хөрөнгө	92,714.9	92,528.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	4,782,610.6	6,027,231.6
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	18,262.2	1,883.7
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	18,262.2	1,883.7
41300	Өглөг	18,262.2	1,883.7
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	4,764,348.4	6,025,347.9
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,764,348.4	6,025,347.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	974,241.4	974,241.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,786,099.0	4,059,030.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,004,008.0	992,076.4
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	4,782,610.6	6,027,231.6

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,978,806.9	4,544,464.8
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	358,191.0	428,937.9
110	Орлогын албан татвар	242,142.4	301,273.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	242,142.4	329,220.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-27,947.4
113	Хөрөнгийн албан татвар	57,422.9	70,922.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	58,625.7	56,741.7
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	240,897.0	1,510,216.9
120	Нийтлэг татварын бус орлого	240,897.0	1,510,216.9
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,379,718.9	2,605,310.0
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	3,106,136.2	3,271,533.6
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,106,136.2	3,271,533.6
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,821,424.7	3,269,621.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,800.0	607,220.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,180.5	74,446.3

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	483,489.7	694,675.2
2104	Хангамж, бараа материалын зардал	469,842.2	557,958.0
2105	Нормативт зардал	335.3	520.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,478.5	4,466.9
2107	Томилолт, зочны зардал	4,991.2	6,369.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,508.2	929,327.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	338,799.2	394,637.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,284,711.4	1,912.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-127,329.3	1,272,931.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,126,007.6	1,272,931.1

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,864,931.0	3,186,921.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	358,191.0	428,937.9
110	Орлогын албан татвар	242,142.4	301,273.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	242,142.4	329,220.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-27,947.4
113	Хөрөнгийн албан татвар	57,422.9	70,922.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	58,625.7	56,741.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,271.6	15,759.1
1181	Газрын төлбөр	3,590.2	22,381.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	44,763.8	18,600.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,043.4	152,673.5
120	Нийтлэг татварын бус орлого	107,043.4	152,673.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,399,696.6	2,605,310.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,413,823.5	2,490,919.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,413,823.5	2,490,919.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,116,609.4	2,489,006.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,939.9	604,323.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,524.0	73,491.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	483,994.7	694,675.2
2104	Хангамж, бараа материалын зардал	25,711.3	33,765.1
2105	Нормативт зардал	485.3	652.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,155.9	5,294.4
2107	Томилолт, зочны зардал	3,491.2	6,369.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,418.2	964,869.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,889.0	105,565.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,297,214.1	1,912.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	451,107.6	696,002.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	432,683.5	559,658.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	432,683.5	559,658.1
2200	Дотоод эх үүсвэрээр	432,683.5	559,658.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-432,683.5	-559,658.1

<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-100.0	-140,100.0
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	100.0	140,100.0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	18,324.1	-3,755.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	182,745.2	201,069.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	201,069.3	197,313.6

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,468,482.9	2,192,999.0	3,287,655.3	8,949,137.1
<b>10</b>	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	974,241.4	1,004,008.0	2,786,099.0	4,764,348.4
<b>3</b>	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	974,241.4	1,004,008.0	6,912,106.6	8,890,355.9
<b>2</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,494,241.5	-1,188,990.9	3,624,451.3	(58,781.2)
<b>9</b>	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-4,126,007.5	(4,126,007.5)
<b>11</b>	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	974,241.4	1,004,008.0	2,786,099.0	4,764,348.4
<b>20</b>	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	974,241.4	992,076.4	4,059,030.2	6,025,347.9
<b>13</b>	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	974,241.4	1,004,008.0	2,786,099.0	4,764,348.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	-11,931.6	0.0	(11,931.6)
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	1,272,931.1	1,272,931.1

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,149,071.5</b>	<b>2,080,218.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,394,121.5</b>	<b>1,380,460.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,392,042.0</b>	<b>1,378,547.8</b>
<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,455.9	604,323.2
210101	Үндсэн цалин	373,237.0	374,836.5
210102	Нэмэгдэл	162,530.8	136,899.6
210104	Урамшуулал	10,919.4	43,907.6
210105	Гэрээт ажлын хөлс	60,768.7	48,679.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,372.6</b>	<b>73,491.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,538.2	51,751.1
210202	Тэтгэмжийн даатгал	6,644.3	5,771.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,850.7	3,595.6

210204	Ажилгүйдлийн даатгал	1,212.7	1,427.4
210205	Эрүүл мэндийн даатгал	12,126.7	10,946.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>564,365.8</b>	<b>560,598.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	36,995.1	35,518.4
210302	Түлш, халаалт	521,340.5	520,766.8
210303	Цэвэр, бохир ус	6,030.2	4,313.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,765.1</b>	<b>33,765.1</b>
210401	Бичиг хэрэг	5,969.8	5,969.8
210402	Тээвэр, шатахуун	23,976.1	23,976.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,619.2	3,619.2
<b>2105</b>	<b>Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс</b>	<b>200.0</b>	<b>200.0</b>
210503	<b>Нормативт зардал</b>	<b>652.5</b>	<b>652.5</b>
<b>2106</b>	<b>Нормын хувцас, зөөлөн эдлэл</b>	<b>652.5</b>	<b>652.5</b>
210603	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,832.5</b>	<b>11,832.5</b>
210604	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.6	280.6
<b>2107</b>	<b>Урсгал засвар</b>	<b>11,551.9</b>	<b>11,551.9</b>
210702	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,290.6</b>	<b>6,369.4</b>
<b>2108</b>	<b>Дотоод албан томилолт</b>	<b>7,290.6</b>	<b>6,369.4</b>
210801	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,671.2</b>	<b>16,174.4</b>
210802	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,801.3	14,801.3
210803	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	459.4	-
210804	Даатгалын үйлчилгээ	145.0	145.0
210805	Тээврийн хэрэгслийн татвар	240.0	227.2
210806	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.0	20.0
210807	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	872.5	872.5
<b>2109</b>	<b>Газрын төлбөр</b>	<b>123.0</b>	<b>108.4</b>
210901	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>73,635.8</b>	<b>71,340.8</b>
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	49,188.0	46,893.0
<b>213</b>	<b>Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх</b>	<b>24,447.8</b>	<b>24,447.8</b>
<b>2132</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,079.5</b>	<b>1,912.5</b>
213209	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,079.5</b>	<b>1,912.5</b>
<b>22</b>	<b>Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал</b>	<b>2,079.5</b>	<b>1,912.5</b>
220001	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>612,223.9</b>	<b>559,658.1</b>
221001	Барилга байгууламж	335,166.9	335,166.9
222001	Их засвар	199,989.3	173,423.5
223001	Тоног төхөөрөмж	5,006.5	5,006.5
<b>23</b>	<b>Бусад хөрөнгө</b>	<b>72,061.2</b>	<b>46,061.2</b>
230001	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>142,726.1</b>	<b>140,100.0</b>
<b>III</b>	<b>Эргэж төлөгдөх зээл</b>	<b>142,726.1</b>	<b>140,100.0</b>
<b>32</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,149,071.5</b>	<b>1,972,355.3</b>
320001	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,968,679.2</b>	<b>1,920,186.2</b>
320002	Орон нутгийн төсвөөс	1,493,073.5	1,444,580.5

<b>35</b>	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	475,605.7	475,605.7
350001	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>180,392.3</b>	<b>52,169.1</b>
350002	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,605.0	5,605.0
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,726.1	46,564.1
4	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	32,061.2	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		182,210.0
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		74,346.9
<b>61</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>87</b>	<b>87</b>
610001	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>
<b>62</b>	Төсвийн байгууллага	3	3
620001	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	42	42
620002	Удирдах ажилтан	11	11
620003	Гүйцэтгэх ажилтан	13	13
620004	Үйлчлэх ажилтан	5	5
<b>65</b>	Гэрээт ажилтан	13	13
650001	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>42</b>	<b>42</b>
650009	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650010	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	17

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>39,620.7</b>	<b>1,118,778.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>39,620.7</b>	<b>1,118,778.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>39,620.7</b>	<b>1,110,458.6</b>
<b>2104</b>	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	545,259.2
210402	Түлш, халаалт	-	545,259.2
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	530,975.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,227.0	530,975.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,393.7</b>	<b>34,224.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,541.0	34,224.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,852.7</b>	<b>8,319.4</b>
<b>2132</b>	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,319.4
213209	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		8,319.4
<b>22</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>39,620.7</b>	<b>1,118,778.0</b>
<b>2200</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>39,620.7</b>	<b>1,118,778.0</b>
221001	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	<b>39,620.7</b>	308,690.5
222001	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	777,078.4
<b>I</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,360.5

1311	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	27,648.7
------	--	---	----------

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34,000.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup>, зөрчил илэрснээс аудитын явцад 34,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

- Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах оролцооны 10.0 сая, Улаан хүрээ багийн гүүрний засварын 6.0 сая, Рашаант 50-д дулааны шугам татах оролцоо 18.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн ажлуудыг хийж дуусаагүй, шийдвэр гараагүй байгаа тул урьдчилж гарсан зардлаа бүртгэв

Аудитаар нийт 9,149.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 9,149.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

#### 3.1 Зөвлөмж

##### 3.1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** “Залуучуудын гэрэлт гудамж” төсөл тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулсан, “Төв гудамжны тохижуулалт”, “Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах”, “Ботгон багийн засвар”, “Олзвойн хөшөөний өргөтгөл”, “Соёлын төвийн хөгжим”, “Халуун усны хашааны засвар”, “Төгрөг гол багийн тохижилт”, “Нийтийн эзэмшлийн талбай тохижуулах” зэрэг төсөл арга хэмжээний ажлууд нь төсөв эдийн засгийн үзүүлэлт тооцоогүй, зарцуулалтын анхан шатны баримтгүй, ажлын даалгавар байхгүй, “Албан байгууллагын гэрэлтүүлэг”, “Спорт заалны засвар акустик”, “Соёлын төвийн урлагийн хувцас”, “Авто зогсоол амралтын талбай” “, “Спорт заалны гадна засвар”, “Улаан хүрээ багийн мал угаах ванн”, “Зэрэг гол багийн мал угаах ванн” нэртэй хөтөлбөр арга хэмжээ нь иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй ажлууд санхүүжүүлсэн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.3.2 “ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх”, “ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх”, “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

**Өгсөн зөвлөмж:** Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу төлөвлөх, төсөв, эдийн засгийн үзүүлэлт тооцоолол, ажлын даалгавар хийх, сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээ бүрээр хүлээн авсан тухай акт үйлдэх, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, ОНХС-ийн хөрөнгийг журамд заасны дагуу төлөвлөн баталж, зарцуулах

##### 3.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой

**Илрүүлэлт:** Гамшгаас хамгаалах зардалд 8.0 сая, Тэрбум мод хөтөлбөрийн шатахууны зардалд 1.1 сая төгрөгийг зарцуулсан, жолоочийн тооцоо бодоогүй, замын хуудасгүй, хэрэгжүүлсэн ажлын тайлангүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, *шатахууны тооцоог бүрэн бодож хэвших*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Орон нутгийн хөгжлийн сан	Залуучуудын гэрэлт гудамж тендэр зарлаагүй, шууд гэрээ байгуулсан, Төв гудамжны тохижуулалт, Рашаант тавьтад дулааны шугам татах оролцоо хүлээн авсан акт, ажлын даалгаваргүй, Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах төсөвгүй, Ботгон багийн засвар хүлээн авсан актгүй, Олзвойн хөшөөний өргөтгөл төсөвгүй, Соёлын төвийн хөгжим гэрээ, төсөв байхгүй, Халуун усны хашаа зураг төсөвгүй, Төгрөг гол багийн тохижилт, Нийтийн эзэмшлийн талбай тохижуулах зураг төсөв, ажлын даалгаваргүй, Албан байгууллагын гэрэлтүүлэг, Спорт заалны засвар акустик, Соёлын төвийн урлагийн хувцас, Авто зогсоол амралтын талбай, Спорт заалны гадна засвар, Улаан хүрээ багийн мал угаах ванн, Зэрэг гол багийн мал угаах ванн ажлуудыг , иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй ажлууд санхүүжүүлсэн	1	0					1	0		
	Гамшигаас хамгаалах зардалд 8.0 сая, Тэрбум мод хөтөлбөрөөс шатахуунд зарцуулсан 1.1 сая төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудас, хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан байхгүй	1	9,149.0	0	0	0	0	0	1	9,149.0	0
		<b>2</b>	<b>9,149.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>9,149.0</b>	<b>0</b>	<b>0</b>

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		